



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Г Нэрийн дансны 2023 оны орлогод  
тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай Г

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалт Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журам”, Үндэсний статистикийн хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2023 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 14.3 хувиар баталсугай.
2. Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2022 оны үлдэгдэл, 2023 оны орлогод тус тус хүү тооцох ажлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд даалгасугай.

ДАРГА



Х.БУЛГАНТУЯА